

2023 ОНЫ СХТТШ-Д ТЭНЦСЭН ИРГЭДИЙН АНХААРАЛД

(АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР)

2023.09.08

БНСУ-ын Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт **2 ДУГААР ЭЭЛЖИЙН (АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР) УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН 271 ИРГЭДИЙН** жагсаалт болон ЭМҮШ-д хамрагдах хуваарийг тус тус танилцуулж байна.

Энд дарж шалгана уу

1. Аж үйлдвэрийн салбарт тэнцсэн иргэдийн жагсаалт

Шалгалтад хамрагдсан иргэн бүр EPS-ийн цахим хуудас (www.eps.go.kr)-аас шалгалтын оноогоо шалгах боломжтой.

○ Шалгалтын оноог шалгах арга

- ① "EPS-ТОPIK" вэб сайтад хандах (eps.hrdkorea.or.kr/epstopik)
- ② Хэл сонгох (Солонгос эсвэл Англи)
- ③ "Тестийн үр дүн" болон "Шалгалтын үр дүнг харах" дээр дарна уу.
- ④ Паспортын (ID) дугаар болон төрсөн огноог оруулна уу.

Нэг. Шалгалтад тэнцсэн иргэдийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдах заавар:

- ✓ Гадаад паспорт эсвэл иргэний үнэмлэх, цээж зураг 1 хувь;
- ✓ Ерөнхий шинжилгээний төлбөр 133,000 төгрөг (*ХӨСҮТ-ийн кассанд тушаах*);
- ✓ Зориулалтын саванд өлөн шээс авч очих (*эмийн сангаас зориулалтын сав авах*);
- ✓ Шинжилгээ өгөхийн өмнөх өдөр спиртийн төрлийн шингэн, хэт чихэрлэг болон өөх тостой хоол, хүнс хэрэглээгүй байх;
- ✓ Шинжилгээнд өөрийн өмнөөс өөр хүн оруулахыг хориглох;
- ✓ Амны хаалт (маск) заавал хэрэглэх;
- ✓ Халдвар хамгааллын дэглэмийг баримтлах /Цаг болон хувийн зохион байгуулалтыг маш сайн хангах/;
- ✓ 09:00-12:00 цагийн хооронд хуваарьт өдрийн дагуу шинжилгээнд хамрагдах;

Эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэдээлэл

Эмнэлгийн нэр	Байршил	Шинжилгээ өгөх өдөр, цагийн хуваарь	Шинжилгээ авах хэсэг	Холбоо барих утас
ХӨСҮТ	Баянзүрх дүүрэг , Намьянжүгийн гудамж, 4 дүгээр хороо	09-р сарын 11~09.15-ны өдрүүдэд 09:00-12:00 цаг	ХӨСҮТ-ийн 1-ийн Б байр 1 давхарт	11-453849

Хоёр. БНСУ-ын Хөдөлмөрийн биржид ажил хайгчийн бүртгэл хийлгэх заавар:

Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд тэнцсэн иргэд БНСУ-ын хөдөлмөрийн биржийн ажил хайгчаар байршуулах бүртгэлийг **2023 оны 09 дүгээр сарын 14-ий өдрөөс** Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2 давхар, 207 тоотод эхлүүлэх тул **ӨӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ХУВААРЬТ ӨДРИЙГ** СОНГОН АЖЛЫН ЦАГААР ИРЖ “АЖИЛ ХАЙГЧИЙН АНКЕТ” БӨГЛӨНӨ.

Ажил хайгчаар бүртгүүлэхэд дараах материалыг бүрдүүлж ирнэ. Үүнд:

- ✓ Цээж зураг 1 хувь (Сүүлийн 6 сард авахуулсан 3,5*4,5 хэмжээтэй, цагаан артай эгц урдаас харсан, бараан өнгийн хувцастай авахуулсан байх);
- ✓ Гадаад паспорт эх хувь (гадаад паспортын хүчинтэй хугацаа нэг жилээс дээш байх);
- ✓ Өөрийн харилцдаг банкны данс эзэмшигчийн тодорхойлолт (дансны хуулга болохгүй);

Дараах хуваарийн дагуу ХХҮЕГ-ын 2 давхарт иргэдийг хүлээн авна.

Ажил хайгчийн бүртгэл хүлээн авах өдөр	Бүртгэлийн дугаар	Хүлээн авах цаг
09-р сарын 14	50402916 - 50403152	Ажлын цаг: 08:30-12:30; 13:30-17:30 цагийн хооронд
09-р сарын 15	50403173 - 50403355	
09-р сарын 18	50403361 - 50403567	
09-р сарын 19	50403577 - 50403830	
09-р сарын 20	50403834 - 50403924	
09-р сарын 21	50403930 - 50404178	
09-р сарын 22	50404195 - 50404494	
09-р сарын 25	50404525 - 50404784	
09-р сарын 26	50404806 - 50405275	
09-р сарын 27	50405285 - 50405344	
09-р сарын 28	50405345 - 50405388	
09-р сарын 29	50405389 - 50405430	
10-р сарын 02	50405431 – 50405499	
10-р сарын 03	50405503 - 50405537	

ГАДААДАД АЖИЛЛАХ ХҮЧ ГАРГАХ ХЭЛТЭС